



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 08 сарын 25 өдөр

Дугаар А/157

Есөнбулаг сум

Гэрээ шууд байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 64 -дүгээр тогтоол, Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2026 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 04 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль, тогтоомж, Засгийн газрын болон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал, аймгийн Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэн ажиллах, орон нутгийн хэвлэл мэдээллийн байгуулагатай зохих хууль журмын дагуу гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Эрдэнэжаргал)-т шилжүүлсүгэй.

2. Гэрээний зардалд шаардагдах 15.000.000 (арван таван сая) төгрөгийг хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газар (Д.Эрдэнэжаргал)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтийг хангаж хөрөнгийн зарцуулалтыг тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг даргын Хэвлэлийн алба (Д.Баяраа)-д, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

D:zahiramjZax ZD 2025

8000010246

